o Хөрөнгийн орлого	2694.0	275.2	10.2	-2418.8
Өмчийн татвар (буу)	60.9	54.2	89.0	-6.7
Бусад төлбөр хураамж	10708.1	7920.8	74.0	-2787.3
o Улсын тэмдэгтийн хураамж	8851.5	6171.1	69.7	-2680.4
o Хог хаягдлын хураамж	1856.6	1749.7	94.2	-106.9
o Бусад татвар	-	-	-	-
<b>Татварын бус орлого</b>	<b>2568.1</b>	<b>1494.0</b>	<b>58.2</b>	<b>-1074.1</b>
o Торгуулийн орлого	2508.6	1427.7	56.9	-1080.9
o Бусад нэр заагдаагүй орлого	-	-	-	-
o Төсөвт газрын өөрийн орлого	59.5	66.3	111.4	6.8

\*-дахин

Тайлант хугацаанд татварын орлого 64.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 93.9 хувиар биелсэн бөгөөд татварын орлогын дийлэнх буюу 87.7 хувь нь хүн амын орлогын албан татвар, 12.3 хувь нь өмчийн татвар болон бусад төлбөр хураамжаас бүрдэж байна.


Хүснэгт 17. Дүүргийн төсвийн нийт зардал, сая төгрөг

Төсвийн зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>Нийт зардлын дүн</b>	<b>121 253.8</b>	<b>114 286.4</b>	<b>94.3</b>	<b>-6 967.4</b>
<b>Урсгал зардлын дүн</b>	<b>108 943.8</b>	<b>106 132.2</b>	<b>97.4</b>	<b>-2 811.6</b>
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>107 104.7</b>	<b>104 634.9</b>	<b>97.7</b>	<b>-2 469.8</b>
Цалин хөлс нэмэгдэл урамшил	38 846.6	35 786.6	92.1	-3 060.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	4 259.4	3 808.0	89.4	-451.4
Бараа үйлчилгээний бусад зардал	26 909.8	31 421.4	116.8	4 511.6
○ Бичиг хэрэг	208.8	153.9	73.7	-54.9
○ Гэрэл цахилгаан	1 756.4	1 488.2	84.7	-268.2
○ Түлш халаалт	1 569.7	1 296.8	82.6	-272.9
○ Тээвэр, шатахуун	85.3	76.5	89.7	-8.8
○ Шуудан холбоо	187.3	138.7	74.1	-48.6
○ Цэвэр, бохир ус	739.5	579.2	78.3	-160.3
○ Бусад	22 362.8	27 688.1	123.8	5 325.3
Нийслэлд төвлөрүүлсэн орлого	37 088.9	33 618.9	90.6	-3 470.0
Урсгал шилжүүлэг	1 839.1	1 497.3	81.4	-341.8
Хөрөнгийн зардал	12 310.0	8 154.2	66.2	-4 155.8
Татаас	4 825.3	3 134.3	65.0	-1 691.0
Харилцах дансны үлдэгдэл	-	-	-	-

Төсвийн нийт зардал 114.3 тэрбум төгрөг байгаа нь төлөвлөсөн хэмжээнээс 7.0 тэрбум төгрөгөөр (5.7%) бага зарцуулсан байна. Нийт зардлын 92.9 хувийг урсгал зардал, 7.1 хувийг татаасын зардалд зарцуулжээ. Харин урсгал зардлын 98.6 хувийг бараа үйлчилгээний зардал, 1.4 хувийг урсгал шилжүүлгийн зардалд зарцуулсан байна.

Бараа үйлчилгээний зардлын 34.2 хувийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 3.7 хувийг ажил олгогчоос НД-д төлөх шимтгэлд, 30.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 32.1 хувийг нийслэлд төвлөрүүлсэн орлогод тус тус зарцуулсан байна.

Зураг 13. Дүүргийн төсвийн нийт зардал, сая төгрөгөөр





## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Тус дүүргийн хувьд Монфреш, Далай ээж-Миний дэлгүүр, Мастер фүүдс-Хүнсний 50-р дэлгүүр, Меркури зэрэг 4 томоохон худалдааны төвөөс хэрэглээний сагсанд сонгогдсон 300 гаруй бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүрийн сүүлийн 7 хоногт цуглуулдаг бөгөөд гол нэрийн хүнсний барааны дундаж үнийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан танилцуулж байна.

Хүснэгт 18. Хүнсний барааны жижиглэн худалдааны дундаж үнийн өөрчлөлт, төгрөг

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2018 XI	2019 XI	Өсөлт, бууралт	
					Төгрөг	Хувь
“Алтан тариа” савласан гурил	Дээдийн дээд	кг	1 925	1 997	72 <sup>↑</sup>	3.7 <sup>↑</sup>
	Дээд	кг	1 548	1 565	17 <sup>↑</sup>	1.1 <sup>↑</sup>
	1-р зэрэг	кг	1 183	1 350	167 <sup>↑</sup>	14.1 <sup>↑</sup>
	2-р зэрэг	кг	970	1 047	77 <sup>↑</sup>	7.9 <sup>↑</sup>
Сүү ХК	Сүү 1л	л	2 753	2 688	-65 <sup>↓</sup>	-2.4 <sup>↓</sup>
	Сүү 0.5л	л	1 170	1 250	80 <sup>↑</sup>	6.8 <sup>↑</sup>
	Тараг цөцгийтэй	л	2 651	2 560	-91 <sup>↓</sup>	-3.4 <sup>↓</sup>
Талх	Атар	ш	1 225	1 280	55 <sup>↑</sup>	4.5 <sup>↑</sup>
	Зууван чех	ш	1 525	1 690	165 <sup>↑</sup>	10.8 <sup>↑</sup>
Цагаан будаа	кг	3 280	3 815	535 <sup>↑</sup>	16.3 <sup>↑</sup>	
Ургамлын тос ‘Янта’	кг	3 955	3 780	-175 <sup>↓</sup>	-4.4 <sup>↓</sup>	
Алим, Фүжи	кг	5 123	5 498	375 <sup>↑</sup>	7.3 <sup>↑</sup>	
Өндөг	ш	380	378	-2 <sup>↓</sup>	-0.5 <sup>↓</sup>	

Хүнсний гол нэрийн бараанаас атар талх, дээд, дээдийн дээд гурил, 2-р гурил, 0,5 л савалгаатай сүү 17-80 хүртэл төгрөгөөр, 1-р гурил, “Зууван чех” талх, 165-167 хүртэл төгрөгөөр, фүжи алим, цагаант будаа 375-535 төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин 1 л савалгаатай сүү 65 (2.4%), цөцгийтэй тараг 91 (3.4%), “Янта” ургамлын тос 175 (4.4%), өндөг 2 (0.5%) төгрөгөөр тус тус буурчээ.


Хүснэгт 19. Хүнсний ногооны дундаж үнийн өөрчлөлт, төгрөг

Үзүүлэлт	Улс	Хэмжих нэгж	2018 XI	2019 XI	Өсөлт, бууралт	
					Төгрөг	Хувь
Төмс	Монгол	кг	935	785	-150 <sup>↓</sup>	-16.0 <sup>↓</sup>
Лууван	Монгол	кг	1 223	1 438	215 <sup>↑</sup>	17.6 <sup>↑</sup>
Байцаа	Хятад	кг	1 298	1 398	100 <sup>↑</sup>	7.7 <sup>↑</sup>
Хүрэн манжин	Монгол	кг	1 898	1 745	-153 <sup>↓</sup>	-8.1 <sup>↓</sup>
Сонгино	Хятад	кг	1 473	1 816	343 <sup>↑</sup>	23.3 <sup>↑</sup>

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүнсний ногооны төрлөөс хүрэн манжин 153 (8.1%), төмс 150 (16.0%) төгрөгөөр тус тус буурсан бол, байцаа 100 (7.7%), сонгино 343 (23.3%), лууван 215 (17.6%) төгрөгөөр тус тус өсжээ.



Зураг 14. Хүнсний ногооны дундаж үнийн өөрчлөлт төгрөг, хувиар




Хүснэгт 20. Махны жижиглэн худалдааны дундаж үнийн өөрчлөлт, төгрөг

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 XI	2019 XI	Өсөлт, бууралт	
				Төгрөг	Хувь
Хонины ястай мах	кг	8 480	9 417	937 <sup>↑</sup>	11.0 <sup>↑</sup>
Үхрийн мах	Ястай	8 720	12 437	3 717 <sup>↑</sup>	42.6 <sup>↑</sup>
	Цул	11 093	12 340	1 247 <sup>↑</sup>	11.2 <sup>↑</sup>

Махны жижиглэн худалдааны дундаж үнийн өөрчлөлтийг авч үзэхэд өнгөрсөн оны мөн үеэс үхрийн цул мах 1247 (11.2%), үхрийн ястай мах 3717 (42.6%), хонины ястай мах 937 (11.0%) төгрөгөөр тус тус өсжээ.

Зураг 15. Махны жижиглэн худалдааны үнийн өөрчлөлт, төгрөг, хувиар




**Шатахууны үнэ:** Тус дүүрэгт байрлах Петровис ХХК-ний 100 айл дахь салбар, Жаст ойл ХХК-ний 32 дахь салбараас шатахууны үнийн судалгааг сар бүр тогтмол авдаг бөгөөд шатахууны дундаж үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дизель түлш 200 (9.3%) төгрөгөөр өсөж, А92 бензин 60 (1.9%), А80 бензин 80 (4.5%) төгрөгөөр тус тус буурсан байна. Мөн оны эхний 1 сартай харьцуулахад А-80 бензин 50 төгрөгөөр, дизелийн түлш 15 төгрөгөөр тус тус өсөж, А-92 бензин 10 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 21. Шатахууны дундаж үнийн өөрчлөлт, төгрөг

Төрөл	Бензин А-80	Бензин А-92	Дизелийн түлш	
Хэмжих нэгж	л	л	л	
2018	I	1 480	1 630	1 720
	II	1 480	1 630	1 730
	III	1 480	1 730	2 010
	IV	1 630	1 730	2 040
	V	1 630	1 730	2 040
	VI	1 630	1 730	2 040
	VII	1 630	1 793	2 077
	VIII	1 630	1 793	2 077
	IX	1 630	1 827	2 120
	X	1 780	1 853	2 140
	XI	1 780	1 853	2 140
2019	I	1 650	1 803	2 325
	II	1 690	1 731	2 283
	III	1 690	1 737	2 283
	IV	1 690	1 737	2 310
	V	1 690	1 903	2 337
	VI	1 690	1 903	2 337
	VII	1 690	1 827	2 330
	VIII	1 690	1 827	2 330
	IX	1 700	1 793	2 340
	X	1 700	1 793	2 340
	XI	1 700	1 793	2 340

Зураг 16. Шатахууны дундаж үнийн өөрчлөлт, төгрөг, хувиар



Хүснэгт 22. Хүнсний барааны жижиглэн худалдааны үнийн зэрэгцүүлэлт, худалдааны төвөөр

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Монфреш		“Далай ээж миний дэлгүүр”		“Хүнсний 50” дэлгүүр		“Меркури” зах		Дундаж үнэ	
			2018 XI	2019 XI	2018 XI	2019 XI	2018 XI	2019 XI	2018 XI	2019 XI	2018 XI	2019 XI
“Алтан тариа” савласан гурил	Дээдийн дээд	кг	2 040	-	1 710	1 840	2 150	2 150	1 800	2 000	1 925	1 997
	Дээд	кг	1 560	1 680	1 430	1 430	1 700	1 650	1 500	1 500	1 548	1 565
	1-р зэрэг	кг	1 200	1 320	1 080	1 180	1 250	1 400	1 200	1 500	1 183	1 350
	2-р зэрэг	кг	960	-	820	890	1 100	1 050	1 000	1 200	970	1 047
Сүү ХК	Сүү ХК 1л	л	2 760	2 760	2 750	2 640	2 800	2 800	2 700	2 550	2 753	2 688
	Сүү ХК 0.5л	л	-	-	1 160	1 290	1 150	1 150	1 200	1 310	1 170	1 250
	Тараг цөцгийтэй	л	2 650	-	2 704	2 420	2 550	-	2 700	2 700	2 651	2 560
Талх	Атар	ш	1 200	-	1 250	1 240	1 200	1 300	1 250	1 300	1 225	1 280
	Зууван чех	ш	1 600	1 820	1 500	1 540	1 400	1 700	1 600	1 700	1 525	1 690
Цагаан будаа		кг	3 180	-	3 660	3 980	-	-	3 000	3 650	3 280	3 815
Ургамлын тос		кг	4 190	-	3 780	3 780	4 350	-	3 500	-	3 955	3 780
Ногоон цай, Гүрж		ш	-	-	1 460	2 290	1 800	-	1 500	1 500	1 587	1 895
Хонины ястай мах		кг	12 000	12 100	6 620	6 850	6 500	-	8 800	9 300	8 480	9 417
Үхрийн мах	Ястай	кг	-	14 500	9 950	10 310	8 210	-	8 000	12 500	8 720	12 437
	Цул	кг	-	-	12 360	10 780	10 920	-	10 000	13 900	11 093	12 340
Төмс	Монгол	кг	850	800	990	690	900	900	1000	750	935	785
Лууван	Монгол	кг	1 100	1 800	990	1 250	1 300	1 200	1 500	1 500	1 223	1 438
Байцаа	Хятад	кг	1 200	1 500	1 190	1 690	1 300	1 200	1 500	1 200	1 298	1 398
Хүрэн манжин	Монгол	кг	1 700	-	1 390	1 490	3000	-	1 500	2 000	1 898	1 745
Сонгино	Хятад	кг	1 600	-	1 290	2 249	1 500	1 700	1 500	1 500	1 473	1 816
Алим, Фүжи	Хятад	кг	5 500	5 000	4 990	5 990	5 500	6 500	4 500	4 800	5 123	5 673
Өндөг	Монгол	ш	400	400	390	380	380	350	350	380	380	378



## АЖ ҮЙЛДВЭР

Албан ёсны статистик мэдээнд хамрагддаг аж үйлдвэрийн салбарын 72 аж ахуйн нэгжүүд оны эхний 11 сард 3212.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 4763.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 9.6 хувиар, борлуулалт 13.3 хувиар өсжээ. Нийт үйлдвэрлэлтийн голлох 81.8 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 16.0 хувийг боловсруулах аж үйлдвэр, 2.2 хувийг цахилгаан дулаан, уур үйлдвэрлэл, үүнтэй уялдаж нийт борлуулалтын 70.3 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрлэл, 28.2 хувийг боловсруулах аж үйлдвэрлэл, 1.5 хувийг цахилгаан дулаан, уур үйлдвэрлэл эзэлж байна.

Хүснэгт 23. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, сая төгрөг


Үзүүлэлт	2018 XI		2019 XI		2019 XI/2018 XI	
	Үйлдвэрлэлт	Борлуулалт	Үйлдвэрлэлт	Борлуулалт	Үйлдвэрлэлт	Борлуулалт
Аж үйлдвэрийн салбар	2 931 981.7	4 205 348.6	3 212 694.6	4 763 225.1	109.6	113.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	2 478 618.9	2 983 996.7	2 626 737.8	3 350 244.6	106.0	112.3
○ Нүүрс олборлолт	415 799.2	90 655.0	500 652.2	116 435.0	120.4	128.4
○ Газрын тос, шатдаг хий олборлолт	49 936.5	49 142.7	50 411.3	48 146.6	101.0	98.0
○ Төмрийн хүдэр олборлолт	2 012 883.2	2 844 198.9	2 075 674.3	3 185 663.0	103.1	112.0
○ Бусад ашигт малтмал олборлолт	-	-	-	-	-	-
Боловсруулах үйлдвэр:	453 362.8	1 221 351.9	514 755.7	1 341 779.4	113.5	109.9
○ Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	26 986.4	26 638.0	31 897.0	31 897.0	118.2	119.7
● Мах, загас, ногоо, тос	9 169.3	9 205.8	10 410.1	10 410.1	113.5	113.1
● Сүү, сүүн бүтээгдэхүүн	15.0	15.0	7.5	7.5	50.0	50.0
● Үр тарианы гурил малын тэжээл	-	-	-	-	-	-
● Хүнсний бусад бүтээгдэхүүн	17 664.8	17 279.9	21 421.3	21 421.3	121.3	124.0
● Ундаа үйлдвэрлэл	137.3	137.3	58.1	58.1	42.3	42.3
○ Тамхи үйлдвэрлэл	-	-	-	-	-	-
○ Нэхмэлийн үйлдвэрлэлт	2 811.0	4 195.8	2243.0	4 756.2	79.8	113.4
○ Хувцас, үслэг арьс боловсруулалт	136.7	136.7	1.8	1.8	1.3	1.3
○ Арьс шир боловсруулах үйлдвэр	27.4	27.4	25.5	25.5	93.1	93.1
○ Мод модон эдлэл үйлдвэрлэл	-	-	-	-	-	-
○ Цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	-	-	-	-	-
○ Нийтлэх хэвлэх, дуу бичлэгийн үйл ажиллагаа	20 446.5	20 447.0	26 944.3	26 944.3	131.8	131.8
○ Кокс шингэн болон цацраг идэвхт түлш	387 381.6	1 154 570.2	433 278.0	1 257 523.8	111.8	108.9
○ Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3 645.5	3 396.0	2 922.6	3 185.9	80.2	93.8
○ Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	3 925.3	3 925.3	3 671.4	3 671.4	93.5	93.5
○ Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	7 287.1	7 287.1	13 188.1	13 188.1	181.0	181.0
○ Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	662.4	662.4	546.5	546.5	82.5	82.5
○ Бичиг хэрэг, тооцоолох техник үйлдвэрлэл	-	-	-	-	-	-
○ Эмнэлгийн багаж хэмжүүр үйлдвэрлэл	42.1	42.1	36.1	36.1	85.7	85.7
○ Мебель тавилга үйлдвэрлэл	10.8	23.9	1.4	2.8	13.0	11.7
○ Боловсруулах үйлдвэрийн бусад	-	-	-	-	-	-
Цахилгаан, дулааны эрчим хүч, үйлдвэрлэл, усан хангамж	-	-	71 201.1	71 201.1	-	-
○ Цахилгаан дулаан, уур үйлдвэрлэл	-	-	71 201.1	71 201.1	-	-
○ Ус ариутгал усан хангамж	-	-	-	-	-	-

Оны эхний 11 сард уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 148.1 тэрбум төгрөгөөр (6.0%), боловсруулах үйлдвэрлэл 61.4 тэрбум төгрөгөөр (13.5%) өссөн үзүүлэлттэй байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрлэлтийн өсөлтөд нүүрс болон төмрийн хүдэр олборлолт, харин боловсруулах аж үйлдвэрийн өсөлтөд хүнсний бүтээгдхүүн, кокс шингэн болон цацраг идэвхт түлш, нийтлэх, хэвлэх, дуу бичлэгийн үйл ажиллагаа, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэлт голлон нөлөөлжээ.

Зураг 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, салбараар, тэрбум төгрөг



Зураг 18. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, сараар, тэрбум төгрөг



Хүснэгт 24. Гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээгээр


Бүтээгдэхүүний нэр	ХН	2018 XI	2019 XI	Өсөлт, бууралт, %-иар
Чулуун нүүрс	мян.тн	9 612.4	7 881.7	-18.0
Газрын тос	бар.	310 440.7	340 079.3	9.5
Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	1 633.9	1 410.3	-13.7
Зэсийн баяжмал металл агууллагаараа 28%	мян.тн	667.5	631.5	-5.4
Алт	кг	1 759.8	1 775.8	0.9
Баяжуулсан коксжих нүүрс /угаасан/	мян.тн	3 841.3	2 389.3	-37.8
Цахилгаан эрчим хүч /салхи/	мян.квт.цаг	-	258 331.8	100.0
Үхрийн мах	тн	20	-	-100.0
Гахайн мах	тн	7.0	17.7	2.5*
Хонины мах	тн	-	50.0	100.0
Адууны мах	тн	567.0	1 305.0	2.3*
Хиамны зүйл	тн	25.0	12.9	-48.4
Банш, бууз, хуушуур	тн	21.6	12.3	-43.1
Утсан, чанасан болон бусад боловсруулалт хийсэн мах	тн	858.4	266.0	-69.0
Ааруул	тн	1.0	0.2	-80.0
Зайрмаг	мян.ш	11.1	10.3	-7.2
Пүнтүүз	тн	39.3	44.0	12.0
Нарийн боов	тн	5 838.5	6 674.0	14.3
Жигнэмэг	тн	247.9	180.0	-27.4
Хэвийн боов	тн	96.0	98.0	2.1
Чихэр	тн	11.3	10.4	-8.0
Ёотон	тн	-	40.2	100.0
Бусад цай	кг	16 930.1	43 267.5	2.5*
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	мян.л	157.0	61.1	-61.1
Сүлжмэл урт, богино оймс, оймс	мян.хос	495.5	464.7	-6.2
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	10.1	7.3	-27.7
Сүлжмэл эдлэл-ноос	мян.ш	1.7	0.7	-58.8
Монгол дээл,тэрлэг	ш	66.0	-	-100.0
Өмд	ш	-	-	-
Эмэгтэй хүүхдийн формын хувцас	ш	617.0	-	-100.0
Эрэгтэй хүүхдийн формын хувцас	ш	518.0	-	-100.0
Бэлтгэлийн хувцас	хос	256.0	-	-100.0
Гэр ахуйн оёмол эдлэл	ш	1 095.7	80.0	-92.7
Савхин түрийвч	ш	603.9	970.5	60.7
Савхин жижиг эдлэл	ш	6 701.9	2974	-55.6
Картон хайрцаг	мян.ш	0.5	-	-100.0
Хорын цаас	мян.ш	798.9	1 308.0	63.7
Ном	мян.х.д.х**	85 624.0	146 352.9	70.9
Сонин, 7хоногт 4 ба дээш гардаг	мян.х.д.х**	20 032.1	14 927.4	-25.5
Сонин, 7хоногт 4-өөс цөөн гардаг	мян.х.д.х**	-	777.4	100.0
Сэтгүүл	мян.х.д.х**	1 484.4	1 491.2	0.5
Эрхийн бичиг, нэрийн хуудас	мян.ш	312.6	430.0	37.6
Бүх төрлийн картууд	мян.ш	274.6	273.0	-0.6
Диплом, Гэрчилгээ г.м үнэт цаас	мян.ш	14.0	14.4	2.9
Ил захидал, урилга, баярын мэндчилгээ	мян.ш	35.1	22.1	-37.0
Танилцуулга, брошюр, каталоги	мян.ш	3 830.2	4 374.9	14.2
Хэвлэмэл хуанли	мян.ш	1.5	3.1	2.1*
Хүснэгт маягт	мян.х.д.х**	2 255.4	2 130.2	-5.6
Хулдаасан хэвлэл	м2	76 723.8	58 403.9	-23.9
Сүрталчилгааны зориулалттай зурагт хуудас	мян.ш	3 353.4	-	-100.0
Гялгар уут	мян.ш	1 536.9	1 595.2	3.8
Хиймэл эрхтэн / протез/	ш	113.0	101.8	-9.9
Эмчилгээ ариутгалын эм бэлдмэл	тн	557.8	266.5	-52.2
Бусад цусан бүтээгдэхүүн	литр	12 069.0	14 202.0	17.7
Гар нүүрийн саван	тн	6.7	15.2	2.3*
Бетон зуурмаг	м3	44 423.9	86 110.4	93.8
Эмульс	тн	-	-	-
Модон сандал	ш	-	-	-
Гал тогооны өрөөний модон тавилга	ш	10.0	13.0	30.0
Гэрийн бусад модон тавилга	ш	128.0	18.0	-85.9
Хуванцар хүрээтэй хаалга, цонх	м2	9 417.4	9 885.1	5.0
Төмөр хаалга, цонх	м2	763.0	18.2	-97.6
Төмөр хашаа хайс	м2	-	507.3	100.0

\*-дахин, \*\* - Мянган хэвлэлийн даралт хуудас

Гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг биет хэмжээгээр нь авч үзэхэд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс гахайн мах 2.5 дахин, адууны мах 2.3 дахин, цай 2.5 дахин, хэвлэмэл хуанли 2.1 дахин, гар нүүрийн саван 2.3 дахин нэмэгдсэн байна.



Зураг 19. Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, биет хэмжээгээр, 2019 оны эхний 11 сард



## ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Оны эхний 11 сард дүүргийн хэмжээнд нийтдээ 3494.6 мян.м<sup>2</sup> талбайг цэвэрлэж, 55.0 мянган тонн хог тээвэрлэсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 5.8 мянган (8.6%) тонноор буурчээ. Хог тээвэрлэлтэд нийт 2400.7 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 210.7 сая төгрөгөөр (8.8%) буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 25. Тээвэрлэсэн хог

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 XI	2019 XI	Өсөлт, бууралт		Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	
				тоо	хувь	2018 XI	2019 XI
Тээвэрлэсэн хог	тн	67 398.4	61 259.0	-6 139.4	-9.1 ↓	2 611 382.4	2 400 708.9
o Орон сууц	тн	32 043.3	29 421.1	-2 622.2	-8.2 ↓	1 134 089.5	1 076 079.3
o Гэр хорооллоос	тн	22 629.3	21 503.9	-1 125.4	-5.0 ↓	845 129.4	797 750.3
o Албан газраас	Тн	-	-	-	-	-	-
o Зам талбайгаас	Тн	-	-	-	-	-	-
o Зуслан	Тн	12 725.8	10 334.0	-2 391.8	-18.8 ↓	632 163.5	526 878.8
o Хур хог	тн	-	-	-	-	-	-

Зураг 20. Нийт тээвэрлэсэн хог, хувиар



Хог тээвэрлэлтэд зарцуулсан хөрөнгийн 1076.1 (44.8%) сая төгрөгийг орон сууцны, 797.8 (33.2%) сая төгрөгийг гэр хорооллын, 526.9 (22.0%) сая төгрөгийг зуслангийн хог тээвэрлэхэд тус тус зарцуулжээ.

Тээвэрлэсэн хогны 48.0 хувийг орон сууцнаас, 35.1 хувийг гэр хорооллоос, 16.9 хувийг зуслангаас тус тус тээвэрлэсэн байна.

## ТООЛЛОГО, СУДАЛГАА



**Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажил (ХАӨСТ):** Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллого 2020 оны 1 сард явагдана. Тооллогын бэлтгэл ажлын хрээнд Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг шинэчлэн хөтлөх, мэдээллийн санг баяжуулах, сайжруулах ажил энэ оны 6 дугаар сараас, мөн Байшин, орон сууцны 2019 оны тооллогын урьдчилсан бүртгэл 9 дүгээр сараас улсын хэмжээнд тус тус хийгдэж байна.



**ХАӨМС**

Засаг захиргааны анхан шатны нэгж дүүргийн 20 хороодод өрхийн дэвтрийг шинэчлэн хөтөлж, Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-д оруулах, баяжуулах, санг сайжруулах ажил эрчимтэй хийгдэж байгаа ба 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүүргийн 34396 өрхийн (89.2%), 125812 хүн амыг (86.6%) хамруулж, Хүн ам, өрхийн мэдээллийн санд 31179 өрхийн (80.9%), 112213 хүн амын (77.2%) мэдээллийг шинэчлэн оруулаад байна.


Хүснэгт 26. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн шинэчлэлтийн явц, хороогоор

Хороо	Хэсэг	ХАӨМС дахь		Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр бүрэн хөтөлсөн				Бүртгэлийн хувь	
		Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрх	Хүн ам
1	9	2 185	8 074	1 935	6 787	2 146	7 611	102.0	92.0
2	4	1 101	3 879	885	2 845	903	2 966	87.6	80.0
3	9	2 320	8 321	1 995	6 818	2 003	7 139	95.3	82.3
4	5	951	3 541	830	2 999	951	3 541	98.2	107.2
5	6	1 276	4 965	1 160	3 901	1 199	4 125	94.0	83.1
6	6	1 583	5 884	1 286	4 819	1 377	5 162	87.0	87.7
7	10	2 497	9 298	2 273	8 159	2 409	8 775	96.5	94.4
8	9	1 722	8 268	1 450	6 754	1 710	6 282	92.2	74.6
9	8	1 488	6 550	1 117	4 105	1 290	4 518	86.7	69.0
10	9	2 342	10 438	1 883	7 319	2 228	9 094	95.1	87.1
11	12	3 588	11 983	2 918	9 669	3 856	11 989	107.7	101.1
12	12	2 052	6 959	1 946	6 600	1 965	6 583	90.6	84.9
13	12	2 334	9 384	1 653	5 980	1 989	7 823	84.2	84.8
14	8	1 574	5 809	968	3 364	986	3 935	62.2	68.5
15	9	1 799	6 629	1 426	5 480	1 439	5 518	81.0	82.5
16	15	3 138	12 402	2 555	10 248	2 664	10 574	84.9	88.3
17	9	1 712	6 605	1 499	5 558	1 499	5 558	86.9	87.2
18	11	2 439	9 286	2 120	8 635	2 120	8 635	86.9	93.0
19	8	947	2 270	828	2 091	780	1 921	82.4	84.6
20	8	1 591	4 713	1 392	4 067	1 590	4 635	99.4	99.6
<b>НИЙТ</b>	<b>179</b>	<b>38 639</b>	<b>145 258</b>	<b>32 119</b>	<b>116 198</b>	<b>34 396</b>	<b>125 812</b>	<b>89.2</b>	<b>86.6</b>

ХАӨМС\*-Хүн ам, өрхийн мэдээллийн сан

Ногоон - хангалттай сайн  
Хар - хангалттай  
Улаан - хангалтгүй

Зураг 22. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн шинэчлэлт, хувиар, хороогоор



## ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ



### БАЙШИН, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ :

Монгол Улсад Статистикийн байгууллагын үндэс суурь тавигдсан 1924 оноос хойш 1935, 1944, 1956, 1963 онуудад Хүн амын тооллого хийсэн бол улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1960 онд явуулсан байдаг. Олон улсын нийтлэг аргачлалын дагуу Хүн ам, орон сууцны тооллогыг 1969 оноос хойш 10 жилийн давтамжтайгаар хийх болж 1979, 1989, 2000, 2010 онуудад түс түс зохион байгуулсан. Харин улс орны хэмжээнд хүн амьдрах зориулалттай сууцны нийт сан хөмрөг, ашиглалтын талаар бүрэн хэмжээний мэдээллийг одоогоор гаргах боломжгүй байна. Тус мэдээллийг гаргах байшин, орон сууцны суурь тооллогыг дэлхийн ихэнхи улс орнууд хаягийн бүртгэлд суурилан явуулж байна.

Монгол Улсын хувьд хаягийн мэдээлэлтэй холбоотойгоор орон сууц болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Барилга, хот байгуулалтын яамны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хаягийн зургийг Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-д нийцүүлэн улсын хэмжээнд хийж гүйцэтгэсэн. Тиймээс шинээр бий болсон хаягийн мэдээлэлд тулгуурлан үндэсний хэмжээнд тулгамдаж байгаа мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын хүрээнд Байшин, орон сууцны тооллогыг хийх нь зүйтэй гэж үзсэн.

Байшин, орон сууцны тооллогын үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хүн амьдрах суух зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлж, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сантай болоход оршино.

Ингэснээр хүн амын орон сууцны хангамжийг сайжруулах чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийг оновчтой боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг бүрдүүлэх, Тогтвортой хөгжлийн зорилгуудын шалгуур үзүүлэлтүүдийг тооцоход хэрэгцээтэй анхдагч мэдээллийг бүрдүүлэхэд хаягт суурилсан Байшин, орон сууцны тооллого ихээхэн ач холбогдолтой юм.

Байшин, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулах ажил эх орны баруун бүсээс эхлэн бүсчлэн зохион байгуулагдсан бөгөөд Нийслэлийн хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 22-ны хооронд явагдаж, дүүргийн хэмжээнд 11 дүгээр сарын 19-нөөс 24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.

Хамрах хүрээ

- Сууцны тусдаа байшин
- Бие даасан тохилог сууц
- Нийтийн зориулалттай орон сууцны байшин, түүний доторх сууц
- Бүх төрлийн гэр /урц/
- Нийтийн байрыг хамруулна.

Дүүргийн тооллогын Түр товчоо бөгөөд Статистикийн хэлтсээс гэр хорооллын бүсэд ажиллах тоологчдыг хороодод хувиарлан, баг тус бүрт зөвлөмж, чиглэл өгч, 11 дүгээр сарын 19-нд тооллогын ажлыг албан ёсоор эхлүүлэн, тооллогын хугацаанд дүүргийн хэмжээнд нийтдээ 95 тоологч ажиллаж, гэр хорооллын гэр болон байшинтай өрх бүрээр хэсгийн ахлагчийн хамт биечлэн орж, ТАБЛЕТ төхөөрөмжөөр тооллогын асуулгыг авч, тооллого бүртгэл, газрын зурагт тэмдэглэгээг хийж ажилласан.

Тооллогод нийтдээ 18000 гаруй сууцны тусдаа байшин, гэр, нийтийн орон сууцыг хамруулж, 124.6 хувьтай тооллогыг амжилттай зохион байгууллаа. Статистикийн хэлтэс буюу дүүргийн тооллогын Түр товчооны дарга, ахлах мэргэжилтэн нар тооллогын явц, 11 хороодын Түр товчоодын ажлын зохион байгуулалт болон тоологч нарын тооллогын бүртгэл, хөтлөлтөд хяналт тавьж, мэргэжил аргагүйгээр ханган ажилласан.

## СОНИРХОЛТОЙ СТАТИСТИК

### (Монгол орны хамгийн хамгийн хамгийн...)

#### МОНГОЛЫН ТӨДИЙГҮЙ ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ ГЭР



Монголын төдийгүй дэлхий дээрх хамгийн том гэр бол 1658 онд Эрдэнэзуу хийдийн чуулганд зориулан баригдаж байсан “Бат-Өлзий” нэртэй гэр юм. Бат-Өлзий нэртэй 20м голчтой энэ том гэрийн шал нь одоо Эрдэнэзуу хийдийн хэрмийн дунд байдаг. Энэхүү гэр нь 18-20 ханатай, 9 метр орчим өндөр. “Бат-өлзий” гэр нь 20 метр голчтой бөгөөд энэ гэрийн шал нь Эрдэнэзуу хийдийн хэрмийн гол дунд байдаг билээ.

Манай оронд 5-6 ханатай, 9-12 ханатай гэрүүд өргөн дэлгэрсэн байдаг. 5-6 ханатай дундаж гэрийн голч 6-7 орчим метр, өндөр нь 3м орчим байдаг бол “Бат-Өлзий” хэмээх гэр 18-20 ханатай 9м орчим өндөртэй байжээ.

#### МОНГОЛЫН ТӨДИЙГҮЙ ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ УГИЙН БИЧИГ

1905 онд бүтээгдсэн Цэцэн хан Шолойн үргийн бичигт 1577-1905 он хүртэлх 328 жилийн дотор төрсөн 11966 хүний нэрийг 5.3 м голчтой даавуун дээр цагираглуулан бичснээрээ Дэлхийн түүхэнд тэмдэглэгдэх хамгийн том үгийн бичиг болсон байна. Энэ үгийн бичиг одоо Үндэсний Түүхийн Архивт хадгалагддаг.

#### МОНГОЛЫН ХАМГИЙН БАРУУН ЗАХЫН ЦЭГ

Монгол орны нутаг дэвсгэрийн хамгийн баруун захын цэг нь Монгол Алтайн нурууны 3243.6 тоот өндөрлөг бүхий мааньт уул , хойд өргөрөгийн  $48^{\circ}58^1$ , Дорнод уртрагийн  $87^{\circ}44^1$ -т оршино.

#### МОНГОЛЫН ХАМГИЙН ЗҮҮН ЗАХЫН ЦЭГ

Монголын хамгийн зүүн захын цэг нь Соёлз уулын зүүн хойд зүгт 7,1 километр зайд орших 1290,0 тоот өндөрлөгийн хилийн 539 дүгээр тэмдэг бүхий модтой хамар , хойд өргөрөгийн  $46^{\circ}53^1$  , дорнод уртрагийн  $119^{\circ}56^1$ -д оршино.

#### МОНГОЛЫН ХАМГИЙН ХОЙД ЗАХЫН ЦЭГ

Монголын хамгийн хойд захын цэг нь Их Саяаны нурууны Монгол Шарын даваа , хойд өргөрөгийн  $52^{\circ}09^1$  , дорнод уртрагийн  $98^{\circ}57^1$ -д оршино.

#### МОНГОЛЫН ХАМГИЙН ӨМНӨД ЗАХЫН ЦЭГ

Монголын хамгийн өмнөд захын цэг нь Орвог гашууны бор толгойн хойд өргөрөгийн  $41^{\circ}35^1$  , дорнод уртрагийн  $105^{\circ}00^1$ -д оршино.



## МОНГОЛЫН ХАМГИЙН ЗАХЫН ЦЭГҮҮДИЙН ХООРОНДОХ ЗАЙ

Монголын хамгийн баруун захын цэг Мааньт уулаас , хамгийн зүүн захын цэг Модтой хамар хүртэл 2392.0 километр. Монголын хамгийн хойд захын цэг Монгол шарын даваанаас , хамгийн өмнөд захын цэг Орвог гашууны бор толгой хүртэл 1259.0 километр юм.

## МОНГОЛЫН ХАМГИЙН ӨНДӨР БА ХАМГИЙН НАМ ЦЭГ

Монголын хамгийн өндөр цэг нь Монгол Алтайн нурууны Таван богд уулын “Найрамдал” оргил далайн түвшнээс дээш 4374,0 километр мөн Мөнххайрхан уулын “Сүхбаатар” оргил далайн түвшнээс дээш 4204.0 километр юм. Монголын хамгийн нам цэг нь Дорнод Монголын тал дахь Хөх нурууны түвшин 560 метр юм.

## МОНГОЛЫН ХАМГИЙН УРТ БА БОГИНО НЭРТЭЙ ГАЗАР



Монголын хамгийн урт нэртэй газар бол Хөвсгөл нуурын зүүн талд орших “Саравчлага хөгшин үүрийн сарьдаг” хэмээх уул юм. Хөвсгөл нуураас ганцхан гол эх аван урсдаг. Тэр нь Эгийн гол юм. Сэлэнгэ мөрөнд цутгадаг Эгийн гол 475 километр урт бөгөөд голын усжих талбай нь 40454 ам километр болно. Эг гол манай хамгийн богино нэртэй газар юм.

## МОНГОЛЫН ХАМГИЙН ХҮЧТЭЙ САЛХИ



1975 оны 7-р сарын 13-нд Ховд аймгийн Алтай сум зэрэг олон газар хүчтэй нөөлөг салхи болсны дотор Агт уулын ард гарсан салхи 7-10 метр өргөн, 1200 метр урт зурвас газрын модыг үндсээр нь булгалж, ёзоороор нь хугалж сүйтгэжээ. Мөн Ховдын Алтайд гарсан салхинд 115 айлын гэрээс 97 нь унаж байсан баримт бий.

Монголын хамгийн хүчтэй газар хөдлөлт 1905 оны 7-р сард Хангайн нурууны баруун хойд салбар болох Ханхөхий, Булнай Уулсын араар 11-12 баллын хүчтэй газар болжээ.

Энэ нь хүч, голомтын цар хэмжээгээр Монголд төдийгүй дэлхийд томоохонд орох бөгөөд уг газар хөдлөлтөөр үүссэн ан цав нь 350 километр урт байжээ. Энэхүү газар хөдлөлтийн тухайд хүмүүс: “Ханхөхий ар Өвгөн овоо гэдэг газар Тэгшдүүрэнгийн арван хэдтэй хүүхэд хариулж явсан хонин сүрэг , дагуулж явсан нохойн хамт тэр их аймшигт хагархайд амь үрэгдсэн”, “Бүжил гэдэг айлын 7 атан тэмээ идэшилж явсан уултайгаа цөмрөн газарт дарагдсан” гэж мэдээллэсэн байдаг. Монголчууд тархай бутархай амьдардаг тул энэ аюулд төдийлөн олон хүний амь осолдолгүй өнгөрчээ. Доорх зураг 7,2 баллын хүчтэй газар хөдлөлтөнд үүссэн гамшиг. Тэгэхээр 11-12 баллын газар хөдлөлтөнд юу болох нь ойлгомжтой.



## МОНГОЛЫН ХАМГИЙН ӨНДӨР МОД



Манай орны ой хөвчийн моддын дотроос хамгийн өндөр нь Жодоо юм. Энэ нь үнэхээр ойн чимэг гоо үзэсгэлэн болсон шилмүүст мод бөгөөд Сэлэнгэ аймгийн Ерөө , Бугантын хөвч тайгад элбэг ургадаг. Жодоо модот ойн агаар элдэв нянгүй болтол цэвэршсэн байдаг тул гадаад орнуудад тийм ойтой газар амралт сувилалын газрууд байгуулдаг ажээ. Жодооны мөчрөөс эфирийн тос ялгаруулж авдаг. Манайд ургадаг Сибирь Жодоо нь өндрөөрөө 24-26

метр , цээжний өндөр дэх ишний бүдүүн нь 40-42 см болно.

Тохиромжтой нөхцөлд 37-38 метр өндөр , 60-80 см хүртэл бүдүүн байх нь элбэг. Жодоо нь 300 орчим жилийн настай бөгөөд 40-50 наснаас эхлэн 200 нас хүрсэн хойноо ч үрээ өгсөөр байдаг. Монгол оронд 1.9 мянган га талбайд Жодоо мод ургадаг. Дэлхийн хамгийн өндөр мод бол Британийн Колумбад (баруун Канад) ургадаг дугласын Жодоо юм. 1902 оны хэмжилтээр 126.5 метр өндөр байжээ.

## МОНГОЛЫН ХАМГИЙН ТОМ СОЛИР

Манай оронд унасан хамгийн том солир бол Ховд аймгийн Булган сумын нутагт 1933 онд унасан 20 тонн жинтэй “Чингисийн мөнгөн дөш” гэх нэртэй солир юм. Мөн “Аж Богд 11” хэмээн нэрлэгдсэн солир 582.2 кг жинтэй ажээ.

## МОНГОЛЫН ХАМГИЙН ХАЛУУН БА ХАМГИЙН ХҮЙТНИЙ ХЭМ

Манай орны хамгийн халууны өндөр хэм 1944 онд Сайншанд хотод  $+40.8^{\circ}\text{C}$  , 1961 онд Говь-Алтай аймгийн Захуй суманд  $+40.0^{\circ}\text{C}$  тус тус тэмдэглэжээ. Харин манай орны хамгийн хүйтэн хэм нь 1969 оны 1-р сарын 27 нд Завхан аймгийн Тосонцэнгэл суманд  $-52.9^{\circ}\text{C}$  болжээ.

Эх үүсвэр : [www.duuren.mn](http://www.duuren.mn)

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗДТГ, 204 тоот

Утас: 70107068, 7010-7098

И-майл: Sukhbaatar\_dist@nso.mn

Веб: www.nso.mn

www.1212.mn

*Governor's office, Room-204*

*Phone: 7010-7068, 70107098*

*E-mail: Sukhbaatar\_dist@nso.mn*

*Web: www.nso.mn*

*www.1212.mn*